БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР

2025 оны ... дугаар сарын ...

# “ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ” ОНӨААТҮГ-ЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ" ОНӨААТҮГ-ЫН

ДАРГА О.ГАНБААТАР ....................

Улаанбаатар хот
2025 он

Агуулга

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ ........................................................................2

ХОЁР.МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ ..................................................................3

ГУРАВ.АЛСЫН ХАРАА ................................................................................9

ДӨРӨВ.ЭРХЭМ ЗОРИЛГО ...........................................................................9

ТАВ.ҮНЭТ ЗҮЙЛС .......................................................................................9

ЗУРГАА.ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ (SWOT........................................................10

ДОЛОО.СТРАТЕГИЙН ЗОРИЛГО ...............................................................12

НАЙМ.БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ ..............................13

ЕС.ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ......................................................14

АРАВ.ХАВСРАЛТ ......................................................................................25

## Нэг. Нийтлэг үндэслэл

2020 онд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдан гарснаар "Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай" хууль шинэчлэгдэн батлагдсан. Энэхүү хуулийн дагуу нийслэлийн түвшинд хөгжлийн бодлого нь дараах бүтэц, уялдаатайгаар хэрэгжинэ. Дунд хугацааны баримт бичигт – "Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", – "Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр" багтана. Эдгээр баримт бичгүүд нь шаталсан, уялдаа холбоотой төлөвлөлтийн зарчмаар хэрэгжих бөгөөд энэ хүрээнд нийслэлийн төрийн байгууллагууд өөрсдийн эрх, чиг үүргийн дагуу стратегийн төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжилтийг нь хариуцан зохион байгуулах үүрэгтэй юм.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 05 дугаар 23-ны өдрийн 73 дугаар тогтоолоор анх Нийтийн тээврийн үйлчилгээний "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ыг байгуулсан түүхтэй. Нийтийн тээврийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь нийслэлийн иргэд, зорчигчдын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх чанар, үр дүнг дээшлүүлэх, иргэдэд шуурхай, боловсон ая тухтай үйлчлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох, замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэх зорилготой байгууллага юм. Тус байгууллага нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг дэлхийн ижил төстэй хотуудын түвшинд хүргэх, үйлчилгээний стандарт, тээвэрлэлтийн норм, дүрэм, аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллах үүрэгтэй. Энэхүү стратегийг боловсруулахад Монгол Улсын Үндсэн хууль, "Алсын хараа -2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр" зэрэг бодлогын баримт бичгийг үндэс суурь болгов.

Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт "Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна." гэж заасан болно. Мөн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 216 дугаар тогтоолоор батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг

хангах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал, загвар"-ын дагуу энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулав. Стратеги төлөвлөгөөг боловсруулахад SMART буюу зорилго тодорхой байх (specific), хэмжиж болохуйц (measurable), зорилгодоо хүрч болохуйц байх (achievable), бодитой байх (realistic), цаг хугацаатай байх (time bound efforts) гэсэн олон улсын суурь зарчмыг баримталсан болно. Нийслэл Улаанбаатар хотын бодлого, эрх зүйн орчинд орж буй шинэчлэл, гадаад, дотоод орчны хурдацтай өөрчлөлт нь тус төвийн үйл ажиллагааг шинэ түвшинд гаргах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна. Энэхүү стратеги нь Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2024-2028 онд баримтлах бодлогын баримт бичиг юм. Стратеги төлөвлөгөөг батлан хэрэгжүүлснээр ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх болно.

## Хоёр. Мандатын шинжилгээ

Засгийн газрын 2016 оны 350 дугаар тогтоолоор баталсан "Төвлөрлийг сааруулах талаар төрөөс баримтлах бодлого", Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Төрийн байгууллагын чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ын дагуу "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын мандатын шинжилгээг хийв. Мандат нь төрийн байгууллагын хуульд заасан чиг үүрэг болон эрх хэмжээтэй салшгүй холбоотой ойлголт юм. Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-д зааснаар "чиг үүрэг" гэж төрийн байгууллага хуульд заасан эрх мэдлийн хүрээнд тодорхой зорилт, үр дүнд хүрэхээр тогтвортой хэрэгжүүлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хэлнэ. Мандатын шинжилгээгээр тус байгууллагын эрхлэх асуудал нь нийт 18 хуулийг хамарч байна. Үүнээс байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд шууд хамаарах 1 хуулийн хүрээнд чиг үүргийг нарийвчлан тодорхойллоо.

Хүснэгт 1.Мандатын шинжилгээ

| Салбарын үйл ажиллагаанд мөрдөж байгаа нийт хууль | 25 хууль | |
|---|---|---|
| Үүнээс | Тухайн салбарын хууль | 18 |
| | Нийтлэг мөрддөг хууль | 13 |
| Үндсэн чиглэл:Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах | | |
| Үндсэн чиг үүрэг | Дэд чиг үүрэг | Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид |
| 1.Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах | 1.1.Нийслэлийн иргэдэд нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг тав тухтай, аюулгүй байдлыг хангасан нийтийн тээврийн хэрэгслээр хүргэх; | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийтийн тээврийн бодлогын газар |
| | 1.2.Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих; | Нийтийн тээврийн бодлогын газар |
| | 1.3.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ явуулахад шаардагдах хүний нөөц (инженер, мэргэшсэн жолооч, засварчин)-ыг бэлтгэх, | Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |

| | | |
|---|---|---|
| | мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах; | |
| | 1.4.Улаанбаатар хотын нийтийн тээвэрт орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, ашиглалтын ажлыг удирдан зохион байгуулж гүйцэтгэлийг хянах; | Нийтийн тээврийн бодлогын газар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |
| 2.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ. | 2.1.Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох ажлын хүрээнд нийтийн тээврийн бодлогын газраас баталсан замналын дагуу ажил үйлчилгээг зохион байгуулж ажиллах | Нийтийн тээврийн бодлогын газар |
| | 2.2.Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх | Нийтийн тээврийн бодлогын газар |
| 3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас цахимаар үзүүлдэг үйлчилгээний тоог 30 хувиар нэмэгдүүлнэ. | 3.1.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан ажиллах | Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |
| 4.Иргэдийн эрэлт, хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн авто машины хэрэгцээг багасгаж, нийтийн тээврээр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ. | 4.1.Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөх, нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлэхэд холбогдох дээд байгууллагад санал өгөх | Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |
| | 4.2."Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолын чанар, аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулж | Нийтийн тээврийн бодлогын газар, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд |

| | | |
|---|---|---|
| | салбарын чадавхыг бэхжүүлэхэд санал, санаачилга гаргаж ажиллах | |
| Удирдлагуудыг Засгийн газар, нийслэлийн засаг дарга, ИТХ-с гарч байгаа шийдвэрүүдийн талаар мэдээллээр хангах | Нийслэлээс гаргаж байгаа бодлого, шийдвэр, төсөл хөтөлбөрийн талаар мэдээллээр хангах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Засгийн газар болон нийслэлээс хэрэгжүүлж буй арга хэмжээ чиг үүргийн хүрээнд өгсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт тавьж ажиллах | |
| | Хамтын ажиллагааг сайжруулах | |
| | Хууль хяналтын байгууллагуудтай хамтарч ажиллах, дэмжлэг авах | |
| Олон нийтэд мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах | Иргэд, олон нийттэй харилцах, иргэдийн санал, өргөдөл гомдлыг шийдвэрлэх | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Гэмт хэргээс урьдчилан сэргийлж хууль сануулсан санамж болон бусад таних тэмдгийг байрлуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| Архив албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх | Албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу эрхлэн хөтлөх, баримт бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллах, лавлагаа байгууллагын архивын ажилтан нөхөн бүрдүүлэлт хийх, хадгалах, ашиглуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд цахим мэдээллийн сан бүрдүүлэх | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Өмнөх оны хөтлөгдөж дууссан баримтыг бүртгэлжүүлэх, архив үүсгэх | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Хөрөнгө санхүүтэй холбоотой захирамжуудыг шилэн дансанд байршуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |

| | | |
|---|---|---|
| Мэдээллийн технологийг сайжруулах цахимжуулах | Мэдээллийн технологийг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтрүүлэх | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Дотоод сүлжээний аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаа хангах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Хэвлэл мэдээллийн байгууллага, сайтуудтай хамтарч ажиллах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Байгууллагын үйл ажиллагаа нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах. | Хүний нөөцийн төлөвлөлт хийх, хэрэгжилтийг зохион байгуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Хөдөлмөрийн дотоод харилцааг зохицуулах, шинээр гарсан хууль тогтоомжийн дагуу шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Ёс зүйн журмыг сахиулах ажлыг зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Албан тушаалын сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах | Нийт ажилчдад гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх. | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |
| Авилгаас урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөж зохион байгуулах, тайлагнах | Авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг компанийн хэмжээнд зохион байгуулах, сурталчлах | Захиргаа удирдлага, хүний нөөцийн хэлтэс |

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын чиг үүргийг холбогдох хууль, тогтоомжид тулгуурлан тодорхойлсон бөгөөд тухайн чиг үүргийг захиргааны эрх хэмжээний ангиллаар авч үзсэн. Энэ хүрээнд Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор баталсан "Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал"-ыг суурь болгон үзвэл дараах байдлаар гарч ирнэ:

1.Бодлого боловсруулах–Үндэсний хэмжээний болон салбар, орон нутгийн урт, дунд, богино хугацааны стратеги зорилт боловсруулах, төлөвлөх, хууль тогтоомжийн төсөл, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандарт тогтоох, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ хийх чиглэлээрх Засгийн газар, яамд болон нутгийн удирдлагын байгууллагуудын эрх хэмжээ хамаарна.

2.Зохицуулалт хийх–Тодорхой үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр төрийн байгууллагаас зөвшөөрөл, лиценз, магадлан итгэмжлэх, гэрчилгээ олгох зэрэг эрх хэмжээ хамаарна.

3.Зохион байгуулах–Тухайн шатны төрийн байгууллагад хуулиар тогтоож өгсөн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг удирдан чиглүүлэх эрх хэмжээ хамаарна.

4.Санхүүжилт–Төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагуудын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт, санхүүгийн дэмжлэг, зардал, хөрөнгө оруулалттай холбоотой эрх хэмжээ хамаарна.

5.Хүний нөөцийн бодлого–Удирдах албан тушаалтан болон албан хаагчдыг томилох, чөлөөлөх, чадавхжуулах, бэлтгэх, давтан сургах, нийгмийн асуудлыг нь шийдвэрлэх зэрэг эрх хэмжээ хамаарна.

6.Хяналт, үнэлгээ хийх–Төрийн байгууллагын дэвшүүлсэн зорилт, түүний хэрэгжилт, хүрсэн үр дүнг шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэх, ажлын чанар, гүйцэтгэлд хяналт шалгалт болон дотоод аудит хийх эрх хэмжээ хамаарна.

7.Үйлчилгээ үзүүлэх–Төрөөс үзүүлэх үйлчилгээг төрийн байгууллага болон нутгийн удирдлагын байгууллага, эсхүл гэрээний үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх эрх хэмжээ хамаарна.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын чиг үүргийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2.Чиг үүрэг, эрх хэмжээ

| № | Чиг үүрэг | Бодлого боловсруулах | Зохицуулалт хийх | Зохион байгуулах | Санхүүжилт | Хүний нөөцийн бодлого | Хяналт, үнэлгээ хийх | Үйлчилгээ үзүүлэх |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нийтийн тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж, үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм, журмыг чанд баримтлан үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах | | | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 1.1 | Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг 30 хувиар нэмэгдүүлнэ. | | | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 1.2 | Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас цахимаар үзүүлдэг үйлчилгээний тоог 30 хувиар нэмэгдүүлнэ. | | | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| 1.3 | Иргэдийн эрэлт, хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн авто машины хэрэгцээг багасгаж, нийтийн тээврээр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ. | | | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |

Холбогдогч талуудыг тодорхойлохдоо "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын бусад байгууллагатай харилцах эрх хэмжээг үндэслэв.

Зураг 1."Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд холбогдогч талууд:



Эдгээр холбогдогч талуудын оролцоог мэдээлэх, зөвлөх, санал өгөх, хамтран ажиллах, шийдвэр гаргах гэсэн ерөнхий ангиллын хүрээнд тодорхойлсон болно.

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ нь хуулиар олгосон чиг үүргээ хэрэгжүүлэхдээ эдгээр холбогдогч талуудтай харилцах бөгөөд холбогдогч талууд өөрт хамаарах эрх хэмжээний хүрээнд тодорхой үүрэг оролцоотойгоор хамтран ажиллана.

Хүснэгт 3. Холбогдогч талуудын оролцоо:

| Холбогдогч талууд | Оролцоо | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мэдээлэх | Зөвлөх, эргэх холбоогоор хангах | Санал өгөх | Хамтран ажиллах | Шийдвэр гаргах | Хяналт тавих |
| Нийслэлийн Засаг дарга | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| Нийслэлийн Засаг даргын Тамгын газар | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| НИТХ | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| УИХ | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Засгийн газар | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| ЗГХЭГ | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Нийтийн тээврийн бодлогын газар | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ | ✓ |
| Засгийн газрын агентлагууд | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Нийслэлийн хэрэгжүүлэгч агентлагууд | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Зам, тээврийн хөгжлийн яам | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Дүүргийн Засаг даргын тамгын газар | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| ААНБ | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Олон улсын байгууллага | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагууд | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |
| Хэвлэл мэдээллийн байгууллага | ✓ | ✓ | ✓ | ✓ | | |

## Гурав. Алсын хараа

Нийтийн тээврийн үйлчилгээг стандартад нийцүүлэн хэрэгжүүлэх, улс эх орны хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулах

## Дөрөв.Эрхэм зорилго

Нийтийн тээврээр шуурхай боловсон, ая тухтай, үйлчилгээг зорчигчдод хүргэх

## Тав.Үнэт зүйлс

Үйлдвэрийн газрын нийт ажилтан, ахмад үе, тэдний бий болгож бүтээсэн соёл, хамт олон, хувь хүний итгэл, нэр хүнд, ажилтан нэг бүрийн үнэнч, шударга байдал, идэвх чармайлт, өөрийн болон хамт олныг зөв хандлагад төлөвшүүлэх, бие биенээ тусалж дэмжих, өөрийгөө болон бусдыг хүндэтгэх нь үнэт зүйл юм.

## Зургаа.Орчны шинжилгээ (SWOT)

Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын өмнө тулгамдсан асуудал, цаашид хүрэхээр зорьж байгаа зорилго, зорилт, түүнийг хэрэгжүүлэх стратегийг тодорхойлохын тулд SWOT болон PESTLE шинжилгээг дотоод болон гадаад хүчин зүйлийн хүрээнд хийлээ.

Стратегийг боловсруулахын тулд хуулийн хүрээнд тодорхойлогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх чадавхийн өнөөгийн давуу, сул тал, орчны нөлөөллийн боломж, эрсдэлийг илэрхийлэх гол хүчин зүйлсийг тус тус сонгож авсан болно.

Стратегийн зорилтыг тодорхойлохдоо тус шинжилгээний үр дүнд тулгуурлан давуу талдаа түшиглэн, сул талаа бууруулахад чиглэсэн арга замыг сонгож, гадаад орчны боломжийг ашиглаж, эрсдэлийг бууруулах зарчмыг баримталсан.

| ДОТООД ХҮЧИН ЗҮЙЛ | |
|---|---|
| **Давуу тал:** | **Сул тал:** |
| 1.Үйл ажиллагаа жигдэрсэн, тогтвортой<br>2.100% нь мэргэшсэн жолооч нар нийтийн тээврийн үйлчилгээ үзүүлдэг.<br>3.Нийтийн тээврийн үйлчилгээнд явж байгаа тээврийн хэрэгсэл 100% парк шинэчлэл хийгдсэн.<br>5.Ажилтан, албан хаагчдын цалин хөлс 100% нэмэгдсэн.<br>6. Дэд бүтцэд холбогдсон.<br>7. Тариф/ үнэлгээ харьцангуй хямд тул иргэдийн өдөр тутмын суурь хэрэгцээг хангадаг. /дамжин суухад үнэгүй/<br>8. Бэлэн дэд бүтэц, маршрут, зогсоолын тогтолцоо бүрдсэн.<br>9.Төрийн дэмжлэг, бодлогын зайлшгүй хэрэгцээтэй салбар тул санхүүжилт, бодлогын дэмжлэг авах боломж өндөр.<br>10. Тээврийн аюулгүй байдлын журам, стандартуудтай тул стандартчилагдсан үйлчилгээ үзүүлэх давуу талтай.<br>11. Ахмадууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сурагчдийн хэрэгцээг хангадаг. | 1.Ажлын байр хол тул хүний нөөцийн хөдөлгөөн ихтэй.<br>2.Албан хаагчдын ажил үүргийн хуваарь жигд бус.<br>3.Хэт их ажил, гэнэтийн хугацаатай ажлууд, цагийн менежмент сул<br>4.Ажлын стрессээс үүдэлтэй эрүүл мэндийн асуудлууд<br>5.Мэргэжлийн чадварлаг хүний нөөцийн хомсдолтой<br>6.Ажлын байрны шаардлагад нийцэхүйц хүний нөөцтэй холбоотой асуудлууд.<br>7. Иргэдийн итгэл, сэтгэл ханамж харьцангуй бага |

| Гадаад хүчин зүйл | |
|---|---|
| **Боломж:** | **Эрсдэл:** |
| 1.Нийслэл Улаанбаатар хотын хүн амын нягташил ихтэй холбогдуулан автобусны чиглэл нэмэгдэх боломж.<br>2.Нэгдүгээр эгнээний хөдөлгөөнийг сайжруулах боломж.<br>3.Шинээр шугам болон гаралт нэмэх боломжтой.<br>4.Нийтийн тээврийн автобусны жолооч нарын ОО-ын асуудлыг шийдвэрлэх боломж.<br>5.Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх боломж.<br>6. Хурал, сургалтуудад оролцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх боломж.хэд оролцох боломж.<br>7. Цахилгаан автобус нэвтрүүлснээр шатахуун зардлыг бууруулх, олон улсын төсөл, хөрөнгө оруулалт татах боломж.<br>8. Банк, финтектэй хамтран ухаалаг төлбөрийн системээр орлого ил тод болгох.<br>9. Зогсоолын шинэчлэл /дулаан зогсоол, мэдээллийн самбар/ томоохон станцуудыг хөгжүүлэх | 1.Улс төрийн нөлөөлөл их, бодлого тогтворгүй байдал.<br>2.Замын бөглөрөл ихтэй.<br>2.Өрсөлдөгчид ихтэй.<br>3.Байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл байдлаас шалтгаалж хүндрэлүүд гарах эрсдэл.<br>4.Түлш болон сэлбэгийн үнийн өсөлт.<br>5.Чадваргүй жолооч нар зам тээврийн осол гаргах магадлал өндөр.<br>6.Ажлын стрессээс шалтгаалан ажлаас гарах эрсдэл өндөр.<br>7. Замын хөдөлгөөний түгжрэл нэмэгдэж үйлчилгээг удаашруулах.<br>8. Төрийн бодлогын өөрчлөлт, төсөв багасах. |

Энэхүү SWOT шинжилгээнээс харахад нийтийн тээврийн байгууллагын гол анхаарах зүйлс:

- Парк шинэчлэл
- Автоматжуулалт / ухаалаг систем
- Үйлчилгээний чанарын тогтолгоо
- Зардлын менежмент
- Хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

SWOT шинжилгээ нь байгууллагын дотоод давуу тал болон сул тал, гадаад орчны боломж ба аюул заналыг илрүүлэн тодорхойлох стратегийн чухал хэрэгсэл

юм. Энэхүү 11 шинжилгээний зорилго нь байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ өгч, цаашдын хөгжлийн стратегийг оновчтой төлөвлөхөд оршино.

SWOT шинжилгээ хийснээр байгууллага дотоод нөөц боломжоо бүрэн ашиглах, тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх, мөн гадна орчны эерэг боломжийг ашиглан сөрөг нөлөөллөөс сэргийлэх суурь мэдээллийг олж авдаг. Иймд SWOT шинжилгээ нь стратеги төлөвлөгөө боловсруулах үйл явцын үндэс суурь нь болж өгдөг бөгөөд байгууллагын удирдлага шийдвэр гаргахдаа баримтлах бодит үндэслэл, нотолгоог бүрдүүлдэг. Энэхүү тайланд Нийслэлийн "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын бүтэц, нэгж, хэлтсүүдийн орчны шинжилгээнд үндэслэн, тус байгууллагын SWOT шинжилгээний нэгтгэсэн дүгнэлтийг дэлгэрэнгүй боловсрууллаа. Тус байгууллага нь Нийслэл Улаанбаатар хотын иргэдэд нийтийн тээврийн үйлчилгээг шуурхай, боловсон, ая тухтай хүргэх үүрэгтэй билээ.

Гадаад орчны хувьд SWOT шинжилгээг баяжуулан PESTLE шинжилгээ давхар хийх замаар тодорхойлов.

**Байгууллагын гадаад орчны шинжилгээ (PESTLE)**

| Үзүүлэлт | Хамаарах гол эерэг, сөрөг хүчин зүйлс | Нэмэлт тайлбар |
|---|---|---|
| **Улс төр** | Эерэг тал:<br>-УИХ, Засгийн газрын зүгээс нийслэлд хийгдэх тодорхой ажлуудад чиглэгдсэн тогтоол, хөрөнгө санхүүгийн шийдвэрүүдийг гаргадаг.<br><br>Сөрөг тал:<br>-Улс төрийн болон бусад нөлөөлөл орох магадлал өндөр<br>-Нийгмийн тогтворгүй байдал болон ойлголтын зөрүүтэй байдал | Тус байгууллага нь нийслэлийн захиргаанд харьялагддаг тул хотын удирдлага солигдох, бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан бүтэц, чиг үүрэг өөрчлөгдөх, санхүүжилт тасрах зэрэг улс төрийн эрсдэлтэй. Гэхдээ хууль, захирамжаар тогтоосон статус нь давуу тал болж байна. |
| **Эдийн засаг** | Эерэг тал:<br>-Харьцангүй өндөр цалин хөлс<br>-Төсөв санхүүгийн тогтвортой байдал<br><br>Сөрөг тал:<br>-Инфляцийн өсөлт<br>-Шатахуун, сэлбэг гэх мэт бараа материалын үнийн өсөлт<br>-Импортын бүтээгдэхүүнээс хараат байдал | Байгууллага санхүүгийн хувьд сайн нөхцөлтэй ч улс орны эдийн засгийн хямрал нь төсөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. |

| | | |
|---|---|---|
| **Нийгэм** | Эерэг тал:<br>-Сургалт, хөгжлийн боломж<br>-Хамт олны уур амьсгал, уян хатан цагийн бодлого<br>-Иргэд Апп ашиглаж автобусны байршлыг тодорхойлдог болсон.<br><br>Сөрөг тал:<br>-Иргэдийн итгэл, олон нийтэд танигдах байдал | Уян хатан цагийн зохицуулалттай. Сургалт, хамтын ажиллагаа сайн. Гэхдээ олон нийтэд төдийлөн танигдаагүй, ойгодоггүй буруу ташаа мэдээллийн ойлголт тархах эрсдэлтэй. |
| **Технологи** | Эерэг тал:<br>-Цахилгаан автобусыг шугаманд ашигладаг болсон.<br>-Автобус бүрийг камержуулсан.<br>-Орчин үеийн программ хангамжийн хэрэглээтэй<br><br>Сөрөг тал:<br>-Техник технологийн манай улсын цаг агаар, орчин нөхцөлд зохицох чадвар<br>-Интернэт, дотоод сүлжээний хүндрэлтэй | Техник, программ хангамжийн чадавх өндөр боловч дотоод сүлжээ сул, өгөгдлийн сан бүрдээгүй, мэдээллийн аюулгүй байдал хангалтгүй. |
| **Хууль, эрх зүй** | Эерэг тал:<br>-Тогтоол, захирамжаар баталгаажсан статус<br><br>Сөрөг тал:<br>Байгууллагын статус тодорхой бус | Байгууллагын үйл ажиллагаа захирамжаар баталгаажсан<br><br>Байгууллагын статус тодорхой бус учраас эрх зүйн үндэслэлийг үнэн зөв тодорхойлох боломжгүй. |
| **Байгаль орчин** | Эерэг тал:<br>-Төвийн бүсээс алслагдмал зайтай бүсэд байрладаг<br><br>Сул тал:<br>-Агаар, орчны бохирдол, тоосонцор ихтэй бүсэд байрладаг<br>-Үер усны эрсдэл ихтэй | Байгальтай ойр эрүүл цэвэр агаарыг бүрдүүлэх боломжтой.<br><br>Байршил алс, агааржуулалт муу, оффисын байршлаас шалтгаалан цаг ашиглалт муудаг зэрэг нь тухайн байгууллагын дотоод орчны тав тух, ажлын бүтээмжид сөргөөр нөлөөлдөг. |

## Долоо.Стратегийн зорилго

Стратегийн хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх

2.Олон нийтэд байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, эерэг хандлагыг нэмэгдүүлэх

3.Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулах, төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлэх

4.Хамт олны дунд эерэг хандлагыг төлөвшүүлэх

5.Хүний нөөцийн чадавх, бодлогыг дээшлүүлэх, сайжруулах

6.Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.

7. Авто тээврийн хууль тогтоомж, стандартыг хэрэгжүүлж, аюулгүй байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангах

## Найм.Байгууллагын бүтцийн уялдаа, зураглал



## Ес.Үйл ажиллагааны төлөвлөгөө

| Зорилт | Арга зам | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Санхүүгийн эх үүсвэр |
|---|---|---|---|---|---|
| 1.Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1.1.Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх | Тээврийн хэрэгслийн тоо | 133 | 150 | Өөрийн хөрөнгө |
| | 1.2."Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын автобус паркийн барилгын II ээлжийн барилгыг үргэлжлүүлж барьж дуусгах | Барилга угсралтын ажлын хэрэгжилтийн хувь | 85% | 100% | Нийслэлийн төсөв 16,1 тэрбум төгрөг |
| 2."Олон улсын түвшинд нийцсэн үндэсний стандартыг"-ыг нэвтрүүлнэ. | 2.1.MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | Гэрчилгээ авсан байдал, үйл ажиллагааны үр дүн | - | 80% | Өөрийн хөрөнгө |
| 3.Технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлнэ. | 3.1.Байгууллагын дотоод сүлжээ, интернэтийн найдвартай байдлыг нэмэгдүүлнэ. | 1.Дотоод сүлжээний найдвартай байдал хангагдсан эсэх (хувь) | 60% | 95% | Өөрийн хөрөнгө |
| | | 3.2.Интернэтийн хурд (одоогийн хурдыг 0 утгаар авах) (хувь) | 80% | 95% | |
| | 3.2.Судалгааны мэдээлэл боловсруулах программ хангамжийг шинэчлэнэ. | 1.Программ хангамжийн шинэчлэл (хувь) | 60% | 95% | |
| | | 2.Шинэ программ нэвтрүүлээн эсэх (хувь) | 80% | 95% | |
| | 3.3.Хиймэл оюун ухаан, Big data технологийг ашиглах боломжийг нэмэгдүүлнэ. | 1.Судалгаанд хиймэл оюун ухааныг нэвтрүүлсэн эсэх (тоо) | - | 1 | |
| | | 2.Их өгөгдлийн хэрэглээг нэвтрүүлсэн эсэх (тоо) | - | 1 | |
| | | 3.Хиймэл оюун ухаан, их өгөгдөл ашиглан гаргасан судалгаа (хувь) | - | 50% | |
| | 3.4.Дотоод сүлжээ, серверийн аюулгүй байдлыг сайжруулж, мэдээлэл хадгалах найдвартай орчин бүрдүүлнэ. | 1.Сүлжээний аюулгүй байдал хангагдсан эсэх (хувь) | 60% | 95% | |
| | | 2.Серверийн аюулгүй байдал хангагдсан эсэх (хувь) | 80% | 95% | |
| | | 3.Мэдээлэл хадгалах найдвартай орчин бүрдсэн эсэх (хувь) | 60% | 95% | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4.Нийтийн тээвэртэй холбоотой зөрчлийг бууруулах: | | | | | |
| 4.1 Зам тээврийн хөдөлгөөний зөрчлийг бууруулах | Жолоочийн аюулгүй жолоодлогын анхан ба давтан сургалт жил бүр зохион байгуулах, жолоодлогын хэв маягийг хянах | Жолооч нарын анхан болон давтан сургалтанд хамрагдаж байгаа байдал (хувь) | 80% | 100% | Өөрийн хөрөнгө |
| | Аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (SMS) нэвтрүүлэх, эрсдэл өндөр шугамуудад чиглэсэн арга хэмжээ авах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | |
| 4.2.Ажилтаны /жолооч/ зорчигчтэй үүсэх зөрчлийг бууруулах | Зөрчил намжаах (de-escalation), харилцааны сургалт жил бүр зохион байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | Өөрийн хөрөнгө |
| | Камер, яаралтай дуудлагын систем суурилуулах, Автобус дотор аюулгүй байдлын дүрэм, сануулга мэдээлэл байрлуулах, | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 80% | 100% | |
| 4.3.Тоног төхөөрөмж, техникийн аюулгүй байдлын зөрчлийг бууруулах | Шаардлагатай тоног төхөөрөмж суурилуулах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 100% | Өөрийн хөрөнгө |
| | Үзлэгт байнга хамруулах | Үзлэгт хамрагдах тоо (жилд) | 1 | 2 | |
| 5.Олон нийтэд байгууллагын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байдлаар сурталчлан таниулж, зэрэг хандлагыг нэмэгдүүлнэ. | 5.1.Байгууллагын үйл ажиллагааг энгийн ойлгомжтой хэлбэрээр олон нийтэд хүргэх ажлыг өргөжүүлнэ. | Байгууллагын өдөрлөг зохион байгуулах | 1 | 4 | Өөрийн хөрөнгө |
| | | Олон нийтэд хүргэх сувгийн тоо | 2 | 5 | |
| | 5.2.Дотоодын болон гадаадын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. | 1.Хамтын ажиллагаатай байгууллагын тоо | 1 | 3 | |
| | | 2.Хамтран хэрэгжүүлсэн арга хэмжээ (Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь) | 30% | 95% | |
| | 5.3.Байгууллагын үйл ажиллагаар сурталчлан таниулах үйл ажиллагаар эрчимжүүлнэ. | 1.Цахим системээр сурталчлан таниулах | Сар бүр | Ү/А явагдах бүрт | |
| | | 2.Нийгмийн сүлжээний хандалтын тоо (нийт 4 жилийн хугацаанд хувь) | 30% | 95% | |
| 6.Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалтыг сайжруулна. | 6.1.Үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянана. | Тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх | Тухай бүр | Тухай бүр | Өөрийн хөрөнгө |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 6.2.Чиг үүргийн давхардлыг арилгаж, нэгжүүдийн уялдааг сайжруулна. /Бүтэц зохион байгуулалт хийнэ./ | Албан хаагчийн тоо | 500 албан хаагчтай ажиллаж байна. | Батлагдсан бүтцийн дагуу ажиллана | Өөрийн хөрөнгө |
| 7.Хамт олны дунд эерэг соёл, хандлагыг төлөвшүүлнэ. | 7.1.Ажлын байр, амьдрах орчны нөхцөлийг сайжруулна. | Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшин (хувь) | - | 80% | Өөрийн хөрөнгө |
| | 7.2.Хамт олны дундах эерэг соёлыг төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг эрчимжүүлнэ. | Зохион байгуулсан арга хэмжээний тоо (жилд) | 3 | 5 | |
| | 7.3.Сэтгэл зүй, хамт олны уур амьсгалыг дэмжих сургалт, арга хэмжээг тогтмолжуулна. | Зохион байгуулсан сургалтын тоо (жилд) | 2 | 4 | |
| 8.Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна. | Хүний нөөцийн бодлого аргачлалыг нэгтгэн гүйцэтгэл өөрчлөлтийн тогтолцоог бэхжүүлэх | 1.Хүний нөөцийн бодлогын шинэчлэлийн тоо (жилд) | - | 2 | Өөрийн хөрөнгө |
| | | 2.Ажилтан, албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангасан байдал (хувь) | 20% | 95% | |
| 9.Хүний нөөцийн бодлогыг сайжруулна. | 9.1.Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд холбогдох чиг үүргийн нийслэлийн нутгийн захиргааны бусад байгууллагуудтай хамтран ажиллах, туршлага судлах, ажлын уялдаа холбоог хангах | Туршлага судалсан болон хамтран ажилласан байгууллагын тоо | 1 | 4 | Өөрийн хөрөнгө |
| | 9.2.Гүйцэтгэлийн үнэлгээний системийн үр нөлөөг дээшлүүлнэ. | 1.Албан хаагчдын гүйцэтгэлийн үнэлгээний түвшин | 70% | 95% | Өөрийн хөрөнгө |
| | | 2.Байгууллагын үйл ажиллагааны дотоод үнэлгээний түвшин | 50% | 95% | |
| | 9.3.Ажилтан, албан хаагчдыг сургалтад тогтмол хамруулна. | 1.Гадаадад сургалтад хамрагдсан тоо | 3 | 10 | Өөрийн хөрөнгө |
| | | 2.Дотоодод сургалтад хамрагдсан тоо | 80 | 150 | |
| | 9.4.Шинэ ажилтнуудын дасан зохицох, дадлагажуулах хөтөлбөрийг хэвшүүлнэ. | Хэрэгжүүлэх хөтөлбөр тоо | 2 | 4 | Өөрийн хөрөнгө |
| | 9.5.Албан тушаал дэвших, карьер хөгжлийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ. | Хэрэгжүүлэх хөтөлбөр тоо | 2 | 4 | Өөрийн хөрөнгө |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | 9.6.Хүний нөөц, нийгмийн баталгааны хөтөлбөрийг шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангана. | 1.Хүний нөөцийн хөтөлбөрийн хэрэгжилт | - | 50% | Өөрийн хөрөнгө |
| | | 2.Нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилт | 60% | 95% | |
| **10. Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | |
| Зорилт-10.1 Зорилго, алсын хараа, стратегийг сайжруулна. | Арга хэмжээ 10.1.1. Байгууллагын дотоод, гадаад (сонирхогч талууд) хэлэлцүүлэг зохион байгуулах, тогтолцоог боловсронгуй болгох, хөгжүүлэх | Хэлэлцүүлэг зохион байгуулсан байдал, мэдэж буй түвшин, хувь | 30% | 100% | Өөрийн хөрөнгө |
| | Арга хэмжээ 10.1.2. Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах, тайлагнах механизм бүрдүүлэх | Тайлан гаргаж танилцуулсан тоо (жилд) | 1 | 4 | |
| Зорилт-10.2. Байгууллагын соёл ба манлайллыг хөгжүүлнэ. | Арга хэмжээ 10.2.1. Байгууллагын шаардлагатай журмуудыг шинээр болон шинэчилж боловсруулах, хэрэгжилтийг хангах, журмын хяналтын тогтолцоог сайжруулах | Журмын зөрчлийн тоо хэмжээг бууруулах хувь | 10% | 90% | Өөрийн хөрөнгө |
| Зорилт-10.3. Оролцогч талуудын оролцоог хангана. | Арга хэмжээ 10.3.1. Олон нийтийн оролцоог "ил тод, нээлттэй байдлаар" форум зохион байгуулах | Форум зохион байгуулсан тоо (жилд) | 1 | 4 | Өөрийн хөрөнгө |
| | Арга хэмжээ 10.3.2. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ, үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгааны болон санал авах ажлыг зохион байгуулах | Санал асуулга зохион байгуулсан тоо (жилд) | 2 | 6 | |
| | | Мэдээлэл, сурталчилгааны тоо (жилд) | 2 | 12 | |
| Зорилт-10.4. Тогтвортой үнэ цэнийг бий болгоно. | Арга хэмжээ 10.4.1. Хамт олны дунд зөрэг хандлага, соёлыг төлөвшүүлэх, технологийн шинэчлэлийг нэвтрүүлж, ажлын үр дүн, хүртээмжийг дээшлүүлэх | Өгөгдөл, мэдээллийн сангийн хамгаалалтыг сайжруулах байдал, хувь | 30% | 70% | Өөрийн хөрөнгө |
| | | Өдөрлөг зохион байгуулах тоо (жилд) | 1 | 4 | |
| Зорилт-10.5. Гүйцэтгэл ба өөрчлөлтийн удирдлагыг сайжруулна. | Арга хэмжээ 10.5.1. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. | Гэрчилгээ авсан байдал, үйл ажиллагааны үр дүн | - | 80% | Өөрийн хөрөнгө |
| | Арга хэмжээ 10.5.2. Байгууллагын санхүү, үйл ажиллагааны дотоод | Эрсдэлийн мэдээллийн сан бүрдүүлсэн байх, Эрсдэлийн үнэлгээний тайлан, матрикс | Тухай бүр | Тухай бүр | Өөрийн хөрөнгө |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | хяналтын механизм, эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх | | | | |
| Зорилт-10.6. Оролцогч талуудын сэтгэл ханамж, ойлголтыг дээшлүүлнэ. | Арга хэмжээ 10.6.1. Оролцогч талуудын (иргэд, ААН, ТББ) сэтгэл ханамж, стратеги-хүрээний ойлголтыг тогтмол үнэлэх | Сэтгэл ханамжийн судалгааны тоо | 1 | 4 | Өөрийн хөрөнгө |
| | | Оролцогчдын судалгаанд оролцсон хувь (%) | 50% | 80% | |
| | Арга хэмжээ 10.6.2. Ажилтнуудын санаа бодлыг сонсох дотоод санал асуулга, уулзалтыг тогтмол зохион байгуулж, ажлын нөхцөл, цалин урамшуулал, мэргэжлийн өсөлтийн боломжийг сайжруулах | Ажилчдын сэтгэл ханамжийн индекс хувь | 80% | 100% | |

# АРАВ.ХАВСРАЛТ

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын ажилтан, албан хаагчдаас авсан судалгааны нэгтгэл

**Давуу талууд (Strengths):**

• **Тохилог ажиллах орчин, уян хатан зохицуулалт:** Ажиллах орчны нөхцөл тав тухтай, тохижилт сайтай нь ажилтнуудын бүтээмж, сэтгэл ханамжид эерэгээр нөлөөлж байна. Тодруулбал ажлын цагийн уян хатан бодлого хэрэгжүүлдэг (жишээ нь, ажилтан, албан хаагчдыг сургууль, цэцэрлэг цуглахаар хүүхдээ хүргэж өгөх, авах боломжоор хангаж уян хатан нөхцөлөөр ажиллах цагийн зохицуулалтыг сонголтоор олгох) нь ажилтнуудын хувийн амьдрал, хэрэгцээ шаардлагыг хангах, ажлын тэнцвэртэй байдлыг хадгалах давуу тал болж өгдөг байна

• **Чадварлаг, эрч хүчтэй хүний нөөц ба багаар ажиллах чадвар:** Байгууллагын ажилтнууд нь ажлын ур чадвар, ажлын туршлага ихтэй, боловсролын түвшин өндөр, олон жил тус салбарт ажиллаж байсан хүмүүс тул байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдахад хүрэх эрсдэл багатай. Хамт олон доторх уур амьсгал зэрэг, бие биенийгээ хүндэтгэн дэмждэг тул багаар ажиллах чадвар өндөр байна. Энэ нь нийтийн тээврийн салбарын хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлж, үр дүнг сайжруулдаг. Дотоод нэгжүүдийн хоорондын харилцан уялдаа, мэдээллийн солилцоо сайн байдаг нь яаралтай чухал асуудлыг шийдвэрлэхэд хэлтэс, газруудын хүчийг нэгтгэх нөхцөлийг бүрдүүлж өгдөг.

• **Техник, программ хангамжийн хангалттай байдал:** Орчин үеийн техник технологи бүхий компьютер, программ хангамж сайтай байхын зэрэгцээ, шинэ дэвшилтэт технологийг нэвтрүүлэх боломж нээлттэй байгаа (жишээ нь, хиймэл оюун ухаан, машин сургалт, Big Data зэргийг ашиглах суурь бий).

• **Сургалт хөгжлийн боломж, мэдлэг солилцоо:** Ажилтнуудынхаа мэргэжил, ур чадварыг хөгжүүлэхэд тогтмол анхаарч, дотооддоо сургалт, зөвлөгөө, арга зүйн дэмжлэг үзүүлдэг. Мөн ажилтнуудыг гадаад, дотоодын хурал, семинарт оролцуулах боломжоор хангадаг нь тэдний мэдлэгийг нэмэгдүүлж, олон улсын туршлага судлахад дэмжлэг болдог. Жишээлбэл, сүүлийн 2 жилд хэд хэдэн урсгал засварын засварчин болон инженерүүдийг БНХАУ-д ZK6116HG загварын нийтийн тээврийн автобусны борлуулалтын дараах засвар үйлчилгээний сургалтад хамруулсан нь мэргэжлийн ур чадвар, чадавхийг сайжруулах олон улсын шинэ арга зүй, хандлагыг байгууллагад нэвтрүүлэх нэг үндэс болсон. Мэргэжлийн бус ажилтан ажилд авдаг, хүний нөөцийн

ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх сургалт хангалтгүй, карьер хөгжлийн бодлого тодорхой бус байгаа нь ажилтнуудын ирээдүйд өсөх итгэл сулрах нэг шалтгаан болж байна.

• **Дотоод удирдлага, бодлого төлөвлөлтийн сулрал:** Байгууллагын дотоод зохион байгуулалт, бодлого төлөвлөлт зарим чиглэлээр хоцрогдолтой байна. Тухайлбал, стратегийн төлөвлөгөө, урт хугацааны хүний нөөцийн бодлого, нийгмийн баталгааны бодлого сайн боловсруулагдаагүй байгаа нь тодорхойгүй байдал үүсгэдэг. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах (жишээ нь, эрүүл мэндийн даатгалын нэмэлт үйлчилгээ, орон сууцны дэмжлэг г.м) төлөвлөгөө байхгүй, ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах хөшүүрэг сул гэж дүгнэсэн. Мөн ажлын байрны тодорхойлолтод тусгагдаагүй нэмэлт ажил, үүрэг даалгавар олноор гүйцэтгэх явдал гардаг нь ажлын байрны зорилго, үүргийн хүрээ бүрхэг байх сул талтай. Энэ нь урт хугацаанд ажилтнуудын сэтгэл ханамжийг бууруулж, байгууллагад итгэх итгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

• **Дэд бүтэц, мэдээллийн технологийн хүндрэл:** Дотоод сүлжээ, интернэтийн хурд хангалтгүй сул байгаа нь цахим судалгаа, мэдээллийн солилцооны ажлыг удаашруулдаг. Зарим нэгжид компьютерын вирусийн эсрэг программ суулгаагүй, шаардлага хангахуйц компьютерийн хүрэлцээ муу, мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт сул байгаа нь мэдээлэл алдах, устах, саатах эрсдэлийг дагуулдаг сул тал юм. Мөн байгууллагын хэмжээнд нэгдсэн өгөгдлийн сан, мэдээллийн бааз байхгүй учир хүний нөөцийн судалгаанд шаардлагатай мэдээллийг түргэн шуурхай олж авах, ашиглах боломж хомс байна. Ингэснээр мэдээлэл цуглуулах, эсвэл дутуу мэдээллээс болж алдаатай дүгнэлт хийх эрсдэл дотоод сул тал болж байна.

**Боломжууд (Opportunities):**

• **Эрх зүйн орчин, захиргааны дэмжлэг:** Хууль эрх зүйн хүрээнд бие даасан статустай байгууллага юм. Энэ нь удирдлагын түвшинд өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх эрх зүйн баталгаатай, үйл ажиллагаа нь тогтвортой байх үндэс болж байна. Тухайлбал, тус үйлдвэрийн газрыг байгуулах тухай захирамж, эрх зүйн актууд нь байгууллагын үйл ажиллагааг улс төрийн өөрчлөлтөөс харьцангуй хамгаалах боломжийг бүрдүүлдэг.

• **Хамтын ажиллагаа, сүлжээ өргөжүүлэх боломж:** Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд төрийн болон төрийн бус олон байгууллагатай хамтран ажиллах өргөн боломж байна. Өнөөдрийн байдлаар салбарын болон бусад нийтийн тээврийн

үйлчилгээ эрхэлдэг ОНӨААТҮГ-уудтай нээлттэй мэдээлэл солилцож, хамтарсан ажиллах нөхцөл бүрджээ. Цаашид энэ давуу талаа түшиглэн хамтын ажиллагааны сүлжээг улам өргөжүүлэх, олон улсын байгууллагуудтай түншлэх боломжууд харагдаж байна. Ийнхүү салбар хоорондын, олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх нь байгууллагын нөлөөллийг дээшлүүлэх том боломж юм.

• **Технологийн дэвшил, дата мэдээллийн сан:** Орчин үед мэдээллийн технологийн хурдацтай хөгжлийг ашиглан байгууллагын судалгааны арга барилыг сайжруулах боломж бий. Тухайлбал, хиймэл оюун ухаан (AI), их өгөгдөл (Big Data), машин сургалтын аргуудыг судалгаанд нэвтрүүлснээр илүү нарийвчилсан, урьдчилан таамаглах чадвартай шинжилгээ хийх бололцоо байна. Байгууллагын зүгээс шаардлагатай техникийг хангаж , программ хангамжийн шинэ технологийг нэвтрүүлэх суурь нөхцөл нь болох юм. Өөрөөр хэлбэл, өөрсдийн бий болгосон дата сангууддаа тулгуурлан цаашид ажлаа гүнзгийрүүлэх боломжтой.

• **Нийгэм, эдийн засгийн эрэлт хэрэгцээ:** Төрийн шийдвэр гаргах түвшинд "судалгаанд үндэслэсэн бодлого"-ын хэрэгцээ нэмэгдэж буй энэ үед тус байгууллагын судалгаа, санал зөвлөмжүүд нь онцгой ач холбогдолтой болж байна. Энэ нь байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, шинэ чиглэл санаачлах, төсөв хөрөнгийг нэмэгдүүлэх боломжийг олгож байна.

• **Нэр хүнд, олон нийтийн итгэл:** Хэдийгээр олон нийтэд нийтийн тээврийн үйлчилгээ, автобусны жолооч нарын харилцаа хандлага тэдийлэн таалагддаггүй ч цахим орчинд автобусны жолооч нарын талаарх сөрөг мэдээллийг дарж эерэг мэдээлэл байршуулж энэхүү мэдээлэл нь хурдацтай тархаж байгаатай холбогдуулан байгууллагын нэр хүнд эерэгээр үнэлэгдэж эхэлж байна. Бусад үйл ажиллагааны чиглэл адил байгууллагуудын гаргасан мэдээ, тайланг өөрсдийн ажилдаа ашиглаж хамтран ажиллаж байгаа нь нэр хүндийг өсгөх нэг илрэл юм. Цаашид энэ байр сууриа бэхжүүлж, олон нийтэд эерэг мэдээлэл түгээж, үйлчилгээний имижийг бүрдүүлэх нь байгууллагын үр дүнг нийтийг хамарсан шийдвэрт тусгахад дэмжлэг болох боломж юм.

**Аюул занал (Threats):**

• **Улс төр, эдийн засгийн тогтворгүй байдал:** Байгууллагын үйл ажиллагаа улс төр, засаг захиргааны орчинтой шууд холбоотой тул эдгээрийн өөрчлөлт нь эрсдэл дагуулдаг. Тухайлбал, улс төрийн хараат байдал – хотын удирдлага солигдох, намын бодлого өөрчлөгдөх үед төвийн бүтэц, чиг үүргийг өөрчлөх, санхүүжилтийг танах зэрэг

эрсдэл гарч болзошгүй. Мөн өргөн хүрээтэй эдийн засгийн хямрал, санхүүгийн хүндрэл үүсэх нь төвийн төсөв, хүний нөөцийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх аюултай. Ийм тодорхой бус байдал нь байгууллагын урт хугацааны төлөвлөлтийг ганхуулах, мэргэжилтнүүдийг ажилгүй болох орон тоо хасах, эрсдэлд хүргэх магадлалтай тул болзошгүй аюулын нэг гэж үзэж байна.

• **Мэдээллийн хүртээмж, чанарын эрсдэл:** Шаардлагатай мэдээ, мэдээллийг авахад хангалтгүй байх тохиолдол олон. Өөрөөр хэлбэл, бусад байгууллагаас ирүүлсэн дата мэдээлэл дутуу, алдаатай эсвэл хугацаа хоцорсон байх нь судалгааны дүнг гажуудуулах эрсдэлтэй. Зарим тохиолдолд шаардлагатай мэдээлэл дутагдсанаас буруу дүгнэлт гаргах, эсвэл таамаглалд үндэслэх нөхцөл үүсдэг. Мөн тус байгууллага нь одоогоор нэгдсэн өгөгдлийн сантай бус ажиллаж байгаа нь мэдээлэл цуглуулалт, хадгалалт төвөгтэй болгож, чухал мэдээллээ алдах, аль эсвэл давхардуулж хугацаа алдах эрсдэлийг дагуулж байна.

• **Мэдээллийн аюулгүй байдал, оюуны өмчийн хамгаалалт:** Байгууллагын цахим аюулгүй байдал сул, дотоод мэдээлэл алдагдах эрсдэлтэй. Жишээ нь, вирусийн хамгаалалтгүй компьютероос болж байгууллагын судалгааны өгөгдөл гадагшаа алдагдах, устах магадлал байна.

• **Олон нийтэд танигдах байдлын сул байдал:** Байгууллагын үйл ажиллагаа, хийж буй ажлууд олон нийтэд хангалттай хүрч чадахгүй байгаа нь нэгэн төрлийн аюул боломжийг хязгаарлагч хүчин зүйл болдог. Мэдээллийн технологийн эрин үед цахим орчинд тархсан буруу ташаа мэдээ мэдээллийг олон нийт зөв буруугаар нь ойлгохгүйгээс болж мэдээллийг буруу тараах, гуйвуулах эрсдэл гардаг. Жишээ нь, зарим нэг хариуцлагагүй автобусны жолоочийн буруугаас үүдэлтэй мэдээллийг нь тасалж авч сошиал медиад нийтийн тээврийн байгууллагыг нийтээр нь буруутгах өнгө аястай түгээсэн тохиолдол гардаг. Энэ мэтчлэн олон нийтийн ойлголт, буруу мэдээлэл нь байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй аюул юм.

• **Хүний нөөцийн урт хугацааны эрсдэл:** Дээр дурдсанчлан нийгмийн баталгааны бодлого дутмаг, ажлын ачаалал их зэргээс үүдэн чадварлаг ажилтнуудыг тогтвортой ажиллуулахад хүндрэл учирч болзошгүй. Байгууллагын дотор ажлын байрны баталгаа сул, тодорхой карьерын өсөлт төлөвлөгдөөгүй учир зарим шилдэг мэргэжилтнүүд ажлаасаа гарах эрсдэл үргэлж байдаг. Иймээс чадварлаг боловсон хүчнээ алдах нь байгууллагын өрсөлдөх чадвар, залгамж чанарт ноцтой аюул занал мөн. Нөхцөл байдлын шинжилгээг дүгнэн харвал хууль эрх зүйн хувьд бие даасан статустай, олон

жилийн түүхтэй, удаан оршин тогтнож байгаа, байр суурь бэхжин батжиж байгаа нь бусад ижил төстэй байгууллагуудтай харьцуулахад том давуу тал билээ. Гэхдээ байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй хэд хэдэн чухал сул тал, эрсдэлүүд байна. Ажилтнуудын ажлын ачаалал, цагийн менежмент, хүний нөөцийн бодлого зэрэг дотоод асуудлууд нь шийдвэрлэхгүй бол ажилтны мотивац, байгууллагын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй. Түүнчлэн гадаад орчны улс төр, мэдээллийн тогтворгүй байдал, байгууллагын нэр хүнд, мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой эрсдэлүүдийг үл тоомсорлохгүй байх хэрэгтэй. Эдгээрийг зохицуулан шийдвэрлэснээр тус байгууллага нь өөрийн давуу талуудаа бүрэн ашиглаж, боломжуудаа бодит ажил хэрэг болгох замаар Нийслэлийн нийтийн тээврийн бодлогыг үндэслэлтэйгээр зураглах үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэх боломжтой юм.

**“Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн баримт бичгийн жагсаалт**

**Холбогдох хуулиуд**

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль;
3. Автотээврийн тухай хууль;
4. Компанийн тухай хууль;
5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
6. Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль;
7. Монгол Улсын автотээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль;
8. Иргэний хууль;
9. Төрийн хяналт шалгалтын тухай хууль;
10. Зөрчлийн тухай хууль;
11. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
12. Ахмад настны тухай хууль;
13. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;
14. Цагдаагийн албаны тухай хууль;
15. Дотоодын цэргийн тухай хууль;
16. Гамшгаас хамгаалах тухай хууль;
17. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
18. Зөвшөөрлийн тухай хууль;
19. Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль;
20. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль;
21. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль;
22. Захиргааны ерөнхий хууль;
23. Хөдөлмөрийн тухай хууль;
24. Төрийн болон албаны нууцын тухай хууль;
25. Шилэн дансны тухай хууль;
26. Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;
27. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль;
28. Зар сурталчилгааны тухай хууль;
29. Төсвийн тухай хууль ;
30. Төрийн албаны тухай хууль;

31. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
32. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
33. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль;
34. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;

**Монгол Улсын Олон улсын гэрээ**

1. Тээврийн салбарт хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай /2016.02.05/
2. Улаанбаатар хотын нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээр соёрхон батлах тухай /2015.04.30/

**Улсын дээд шүүхийн тогтоол**

1. Автотээврийн тухай хуулийн зарим зүйл , хэсэг , заалтыг тайлбарлах тухай тогтоол /2006.02.20/

**Монгол Улсын Их Хурлын тогтоол**

1. "Алсын-хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай бодлого /2020.05.13-ны өдрийн 52 дугаар тогтоол/

**Монгол Улсын Засгийн газрын тогтоол**

1. Замын хөдөлгөөний дүрэм батлах тухай /2018.08.08-ны өдрийн 239 дүгээр тогтоол/
2. Тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглох эвдрэл, гэмтэл, техникийн зөрчлийн жагсаалт
3. Автотээврийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /2009.08.18-ны өдрийн дугаар 251/
4. Автотээврийн хэрэгслийг үзлэгт оруулах хугацаа, оношлогооны төлбөрийн жишиг батлах тухай /2004.03.03-ны өдрийн дугаар 55/
5. Автомашин түрээслүүлэх журмыг батлах тухай /1997.06.18-ны өдрийн дугаар 148/
6. Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн тээврийн үнийг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай /2012.02.15-ны өдрийн дугаар 53/
7. Автотээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэг оруулах давтамж, оношлгооны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай /2016.12.28-ны дугаар 213/

8. Нийслэлийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай /2002.01.16-ны өдрийн дугаар 8/
9. Журам батлах, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай /"Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн нийтийн тээврийн хэрэгслээр үнэ төлбөргүй зорчих журам"-ын 3 дугаар хавсралт/, /2017.07.04-ний өдрийн 197 дугаар тогтоол/
10. "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам" /2020.12.09-ний өдрийн 206 дугаар тогтоол/
11. "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам" 2021.12.30-ны өдрийн 246 дугаар тогтоол
12. "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм" /2019.01.23 27-ны өдрийн 33 дугаар тогтоол/
13. "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам" /2020.12.16-ны өдрийн 216 дугаар тогтоол/
14. "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам" /2020.12.16-ны өдрийн 217 дугаар тогтоол/
15. "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам" /2020.12.16-ны өдрийн 218 дугаар тогтоол/

**Сайдын тушаал**

1. Сургалтын хөтөлбөр, журам, үнэмлэхний загвар батлах тухай /Зам , тээвэр, барилга хот байгуулалтын сайд, Боловсрол, Соёл шинжлэх ухааны сайдын тушаал/ /2010.05.07-ны өдрийн дугаар 161/229/
2. Тээвэрлэлттэй холбоотой баримт бичгийг хэвлүүлэх, ашиглах журам /Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.12.08-ны өдрийн 317 дугаар тушаал/
3. Эрх олгох тухай /2016.09.20-ны өдрийн дугаар 31/
4. Жишиг норм батлах тухай /2019.12.30-ны өдрийн 390 дүгээр тушаал/
5. Автотээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм шинэчлэн батлах тухай /2020.01.30-ны өдрийн А/24 дүгээр тушаал/
6. Журам шинэчлэн батлах тухай /Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам/, /2020.11.18-ны өдрийн А/222 дугаар тушаал/
7. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношилгоо явуулах журам батлах тухай /2021.12.31-ний өдрийн А/199 дүгээр тушаал/

8. Авто үйлчилгээний байгууллагуудад ангилал тогтоох журам шинэчлэн батлах тухай /2022.04.25-ны өдрийн А/112 дугаар тушаал/
9. Байгал орчин, аялал жуулчлалын сайд , зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан тушаал /2011 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Дугаар А-63/67/
10. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын тушаал Журам батлах тухай /Авто тээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул , хохирол учруулж болзошгүй ачаа тээвэрлэх журам/ /2009 оны 7 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 188/
11. Монгол Улсын Зам, тээврийн сайдын тушаал /Авто үйлчилгээний ангилал тогтоох/ /2016.04.12-ны өдрийн дугаар 90/
12. Журам батлах тухай зам, тээврийн хөгжлийн Сайдын тушаал /Жишиг норм батлах тухай/ "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм/ /2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 390/
13. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд цагдаагийн ерөнхий газрын даргын дарга нарийн хамтарсан тушаал /2023.07.04-ний өдрийн А 246, А 186 дугаар тушаал/

## Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Тогтоол

1. Нийслэлийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын зарим газрыг өөрчлөн байгуулах тухай /2024.02.28-ны 28 дугаар тогтоол/
2. Удирдах зөвлөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинэчлэн томилох тухай /2024.12.04-ний 24/17/
3. Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн удирдах зөвлөлийн ажиллах журам батлах тухай /2014.04.21-ний 54 дүгээр тогтоол/
4. Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг шинэчлэн батлах тухай /2024.02.08-ны өдрийн дугаар 07/
5. Авто зам ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай /2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр дугаар 02/
6. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн хэрэгцээний авто зогсоолыг төлөвлөх , барьж байгуулах журам батлах тухай /2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн дугаар 16/
7. Нийслэл хотод олгох тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын дээд хязгаарыг тогтоох тухай /2024оны 02 дугаар сарын 08-ны өдөр/
8. Нийслэлийн нутаг дэвсгэрт мөрдөх таксинаас бусад нийтийн тээврийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох тухай /2024 оны 02 дугаар сарын 08- ны өдөр дугаар 21/

9. Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх захиран зарцуулах, хяналт тавих журам батлах тухай / 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Дугаар 03/
10. Хураамжийн хэмжээ тогтоох тухай /2013.03.28-ны өдрийн 8/34 дүгээр тогтоол/
11. "Их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сурагч, оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам батлах тухай" /2015.10.22-ны өдрийн 6/21 дүгээр тогтоол/
12. Журамд өөрчлөлт оруулах тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол /2023 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 99 дүгээр тушаал/
13. "Хүндэт донор" иргэнийг нийтийн тээврийн хэрэгслээр хөнгөлөлттэй зорчуулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2017.06.14-ний өдрийн 95 дугаар тогтоол/
14. Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам /2017 оны 04 дүгээр сарын 27-ны 9/10 дугаар тогтоол/
15. Нийтийн тээврийн үйлчилгээний салбарын санхүүжилтийн журам шинэчлэн батлах тухай /2022.09.07-ны өдрийн 82 дугаар тогтоол/
16. Машин цагийн зардлын тарифыг шинэчлэн батлах тухай /2024.02.28-ны 26 дугаар тогтоол/
17. "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулах журам" /2014.05.05-ны 66 дугаар тогтоол/

**Нийслэлийн Засаг даргын захирамжууд**

1. "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын бүтцийг шинэчлэн батлах тухай /2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/225/
2. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийн хуваарьт зохицуулалт хийх тухай /2024 оны 05 дугаар сарын 31-ний А/630/
3. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2020 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Дугаар А/1037/
4. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай /2023 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/1429/
5. Машин цагийн зардлын задаргааг шинэчлэн батлах тухай /2024.03.21-ний өдрийн А/290/
6. Нийтийн тээврийн бодлогын газрын дүрмийг батлах тухай /2024.05.09-ний А/536/
7. "Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай" /2022.08.15-ны А/1049/

8. "Нийслэлийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас Засгийн газрын шийдвэрийн төсөл санаачлан боловсруулах журам" /2022.04.22-ны А/552/
9. "Нийслэлийн төрийн захиргааны байгууллага, албан тушаалтнаас Засгийн газрын шийдвэрийн төсөл санаачлан боловсруулах журам" /2022.04.22-ны А/552/
10. "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам" /2022.02.02-ны А/52/

—oOo—